

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

2025 оны ...дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар....

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 30 дугаар зүйлийн 30.1, Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.5, Нийгмийн халамжийн тухай хуулийн 16.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Журам шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 362 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хугацаа, олгох журам”-ын 2 дугаар зүйлд 2.13, 2.14, 2.15, 2.16, 2.17, 2.18 дахь хэсэг, 3 дугаар зүйлд 3.6 дахь хэсэг, 4 дүгээр зүйлд 4.4, 4.5 дахь хэсэг, 5 дугаар зүйлд 5.15, 5.16, 5.17, 5.18, 5.19, 5.20, 5.21, 5.22, 5.23, 5.24, 5.25, 5.26, 5.27 дахь хэсгийг доор дурдсан агуулгаар тус тус нэмсүгэй:

1/ 2 дугаар зүйлд 2.13, 2.14, 2.15, 2.16, 2.17, 2.18 дахь хэсэг:

“2.13.Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь энэ журмын 2.8-д заасан комиссын шийдвэрийг тухайн иргэний бодит нөхцөл байдалтай нийцэхгүй гэж дүгнэсэн бол асаргааны тэтгэмжийг түдгэлзүүлж, холбогдох хяналт, шалгалтыг зохион байгуулна. Хяналт, шалгалтаар асаргааны тэтгэмжийг олгох шийдвэр гарсан тохиолдолд түдгэлзүүлсэн хугацаанаас тооцож нөхөн олгоно.

2.14.Энэ журмын 2.8-д заасан комисс нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.6-д заасан байнгын асаргаа шаардлагатай иргэний тодорхойлолтыг дараах хэлбэрээр тогтоож сунгана:

2.14.1.иргэнийг байлцуулахгүйгээр холбогдох нотлох бичиг баримтад үндэслэн;

2.14.2.цахим хэлбэрээр;

2.15.Энэ журмын 2.8-д заасан комисс нь гадаад улсад байгаа эсхүл отор хийж байгаа малчин өрхийн эсхүл байнга оршин суудаг газраас өөр орон нутагт эмчлүүлж байгаа иргэний байнгын асаргаа шаардлагатай тухай тодорхойлолтыг холбогдох нотлох бичиг баримтад үндэслэн мэдээлэл, технологийн шийдлийг ашиглан цахим хэлбэрээр тогтоож сунгана.

2.16.Энэ журмын 2.8-д заасан тодорхойлолтын хугацааг өвчний явц, хүндрэлийг харгалзан, эрүүл мэндийн болон нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтран баталсан өвчин, гэмтлийн жагсаалтыг үндэслэн байнгын асаргаа шаардлагатай байх хугацааг үргэлжлүүлэн сунгах тохиолдолд сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхгүй.

2.17.Байнгын асаргаа шаардлагатай хүүхдийн хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй болохыг Эрүүл мэндийн болон нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтран баталсан өвчин, гэмтлийн жагсаалтыг үндэслэн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс тодорхойлно.

2.18.Төрөлжсөн асрамжийн газарт асруулж байгаа, сэтгэцийн төрөлжсөн мэргэжлийн эмнэлэгт удаан хугацаагаар хэвтэн эмчлүүлж байгаа, хорих ангид ял

эдэлж байгаа хүний тэтгэвэр, тэтгэмжид хамрагдах хүсэлтийг тухайн байгууллагын нийгмийн ажилтан нь байгууллагын байрлаж байгаа газрын нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад хандан гаргана. Нийгмийн ажилтан нь зөвхөн хүсэлт гаргах эрхтэй байх бөгөөд тэтгэвэр, тэтгэмжийг арилжааны банк дахь тухайн иргэний нэр дээрх дансанд шилжүүлнэ.”

2/ 3 дугаар зүйлд 3.6 дахь хэсэг:

“3.6.Энэ журмын 3.2-т заасан бичиг баримтыг бүрдүүлэн байнгын асаргааны тэтгэмж авч байгаа иргэнээс нэмэлт бичиг баримт шаардахгүйгээр Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.5.6 эсхүл 13.5.7-д заасан тэтгэмжийг олгоно.”

3/ 4 дүгээр зүйлд 4.4, 4.5 дахь хэсэг :

“4.4.Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн мөнгийг барьцаалж зээл авах, олгох, банкны болон банк бус санхүүгийн байгууллагын зээлд суутгахыг хориглоно.

4.5.Тэтгэвэр, тэтгэмж авагч нь нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг согтууруулах ундаа, тамхины хэрэглээнд зарцуулахгүй байх үүрэг хүлээнэ.”

5/ 5 дугаар зүйлд 5.15, 5.16, 5.17, 5.18, 5.19, 5.20, 5.21, 5.22, 5.23, 5.24, 5.25, 5.26, 5.27 дахь хэсэг:

“5.15.Төрөлжсөн асрамжийн газарт асруулж байгаа хүүхдийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид хамрагдах хүсэлтийг асрамжийн газрын эсхүл сум, хорооны хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан гаргана.

5.16.Энэ журмын 5.15-д заасан асрамжийн газрын эсхүл сум, хорооны хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан нь төрөлжсөн асрамжийн газарт асруулж байгаа хүүхдэд зөвхөн данс нээлгэх эрхтэй байх бөгөөд тэтгэвэр, тэтгэмжийг арилжааны банк дахь хүүхдийн нэр дээрх хугацаатай хадгаламжийн дансанд шилжүүлнэ.

5.17.Хадгаламжийн дэвтрийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага хадгалж, хүүхдийг 18 нас хүрсний дараа өөрт нь, хүүхэд нас барсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу түүний өв залгамжлагчид нь тооцоо нийлсэн акт үйлдэж хүлээлгэн өгнө.

5.18.18 нас хүрээгүй байхдаа асрамжийн газраас гарч байгаа хүүхдийн төрөлжсөн асрамжийн газарт асруулж байх хугацаанд хугацаатай хадгаламжийн дансанд хуримтлагдсан тэтгэвэр, тэтгэмжийг захиран зарцуулах эрхийг 18 нас хүрсний дараа зөвхөн хүүхдэд өөрт нь олгоно.

5.19.Төрөлжсөн асрамжийн газарт амьдарч байгаа 18 хүртэлх насны мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага, коллежид суралцаж байгаа хүүхдийн тэтгэвэр, тэтгэмжийн 80 хувийг банканд хадгалуулж, 20 хувийг хүүхэд өөрөө захиран зарцуулах зориулалт бүхий харилцах дансыг нээлгэнэ.

5.20.Асрамжийн газар болон орон нутгийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага нь хүүхдийг 18 насанд хүрч хадгаламжийн дансан дахь мөнгөө захиран зарцуулахаас өмнө санхүүгийн мэдлэг, боловсрол олгох сургалтад хамруулж, өөрөө хүсвэл үргэлжлүүлэн хадгаламжид хадгалж, асрамжаас гарч бие даан амьдрахад нь хүлээлгэн өгнө.

5.21.Энэ журмын 5 дугаар зүйлийн 5.15, 5.16, 5.17, 5.18, 5.19, 5.20 дахь хэсэгт хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан аймаг, дүүргийн байгууллага,

хүүхдийн эрхийн улсын байцаагч, сум хорооны хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан хяналт тавьж ажиллана.

5.22.Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын хяналт, шалгалт хариуцсан нэгж нь Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид хамрагдсан иргэнийг зөв тогтоосон эсэх болон амьжиргааг дэмжих зөвлөлийн шийдвэрт түүврийн аргаар төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт, шалгалтыг улирал тутамд хийнэ.

5.23.Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа, ажилтны ёс зүй, харилцаа хандлагыг цаасан болон цахим /киоск, мессеж/ хэлбэрээр үнэлж, сэтгэл ханамжийн судалгааны дүнд үндэслэн үйлчилгээг сайжруулах, сургалт зохион байгуулах арга хэмжээг зохион байгуулна.

5.24.Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээний талаар иргэдийн санал, гомдлыг цаасан болон цахим хэлбэрээр тусгай дугаар бүхий нээлттэй утсаар хүлээн авч шийдвэрлэнэ.

5.25.Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь тэтгэвэр, тэтгэмжид хамрагдсан иргэнийг үнэн зөв тогтоосон эсэхэд хийх хөндлөнгийн болон олон нийтийн хяналт, шалгалтыг тэтгэвэрт гарсан эмч, багш, хуульч зэрэг мэргэшилтэй ахмад настныг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зөвлөх үйлчилгээний хүрээнд сонгон шалгаруулж жилд нэг удаа зохион байгуулна.

5.26.Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох үйлчилгээ үзүүлэх ажилтнуудад сургалт зохион байгуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах ажлыг аймаг, дүүргийн нийгмийн халамжийн байгууллага улирал тутам тогтмол зохион байгуулна.

5.27.Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн байгууллага, ажилтан нь журамд зааснаас гадна нэмэлт бичиг баримт шаардахыг хориглоно.”

2. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хугацаа, олгох журмын 5.4 дэх хэсгийн “асарч болно.” гэсний дараа “Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.2.1, 13.2.2-т заасан иргэнд хүүхдийн тоо хамаарахгүй олгоно.” гэж, 3.3.2 дахь заалтын “байгууллагын” гэсний дараа “акт” гэж, 5.10 дахь хэсгийн “давхар олгоно.” гэсний дараа “Асаргааны тэтгэмж авах хэд хэдэн нөхцөлийг зэрэг хангаж байгаа бол 2-оос доошгүй нөхцөлд тэтгэмжийг олгож болно.” гэж тус тус нэмсүгэй.

3.Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хугацаа, олгох журмын 2.8 дахь хэсэг, 3.3.3 дахь заалтыг доор дурдсан агуулгаар тус тус өөрчлөн найруулсугай:

“2.8.Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.6-д заасан байнгын асаргаа шаардлагатай бусдын туслалцаагүйгээр өдөр тутмын үйлдлээ бие даан гүйцэтгэх чадваргүй иргэний тодорхойлолтыг өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн даргын дүгнэлт, оношлогоо, үзлэг шинжилгээний холбогдох нотлох бичиг баримтад үндэслэн, эрүүл мэндийн болон нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтран баталсан маягтын дагуу дараах комисс тогтоож сунгана:

2.8.1.ахмад настан, 18 ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй иргэний тодорхойлолтыг аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын хяналтын комисс;

2.8.2.оюуны хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн хүнд хэлбэрийн эмгэгтэй иргэний тодорхойлолтыг аймагт нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын хяналтын комисс, нийслэлд сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Эмнэлэг хяналтын комисс;

2.8.3.байнгын асаргаа шаардлагатай 0-18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тодорхойлолтыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын аймаг, дүүргийн орон тооны бус салбар комисс.”

“3.3.3.Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.5.2-т заасан тохиолдолд эцэг, эхийн нас барсны гэрчилгээ, эцэг, эх байх эрхийг нь хассан эсхүл сураггүй алга болсон эсхүл эцэг эх нь эрх зүйн чадамжгүй гэж тогтоогдсон эсхүл гэр бүл салсны улмаас асрамждаа авсан эх /эцэг/ нь нас барсан бол энэ тухай шүүхийн шийдвэр, эцэг эх нь тогтоогдоогүй бол энэ тухай цагдаагийн байгууллагын лавлагаа, тодорхойлолт;”

4.Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хугацаа, олгох журмын 5.13 дахь хэсгийн “тодорхойлолтыг” гэснийг “акт, дүгнэлтийг” гэж, 8.9 дэх хэсгийн “иргэн” гэснийг “иргэнд Эрүүгийн хууль эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэж, мөн журмын 3.2.4, 3.2.5, 3.2.6, 3.2.7 дахь заалтын “13.2.2” гэснийг “13.2.1” гэж тус тус өөрчилсүгэй.

5.Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хугацаа, олгох журмын 2.11 дэх хэсгийн “дүгнэсэн Амьжиргааг дэмжих зөвлөлийн шийдвэрийг үндэслэлтэй гэж” гэснийг, 3.3.1 дэх заалтын “хуулбарын хамт” гэснийг тус тус хассугай.

6.Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хугацаа, олгох журмын 5.3 дахь хэсгийг хүчингүй болгосугай.

7.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакирт, тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар /З.Бауыржан/-т тус тус үүрэг болгосугай.

8.Энэ тогтоолыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ